



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2026.05.28 № 28

Улсын Их Хурлын 2025 оны 120 дугаар
тогтоолын хэрэгжилтийн талаар

“Оюу толгой” бүлэг ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах, хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх хүрээнд хийсэн тусгай шалгалт, нээлттэй сонсголын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2025 оны 120 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих хүрээнд Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуултыг танд тавьж байна.

1.“Оюу толгой” ХХК-ийн 2024-2025 оны хараат бус аудитын компаниар аудитлагдсан, баталгаажсан санхүүгийн дэлгэрэнгүй тайлан (санхүүгийн байдлын тайлан, орлого, зарлагын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон жилийн санхүүгийн тайлангийн тодруулга)-ийн талаар;

2.“Оюу толгой” ХХК-ийн 2024-2025 оны төсөв, төсвийн гүйцэтгэл, менежментийн тайлан, дүгнэлт, нийт борлуулалт, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардлын задаргаа, ашигт ажиллагаа, мөнгөн урсгал, хөрөнгө оруулалт, ашгийн хуваарилалт (эргэн хөрөнгө оруулалт, зээлийн эргэн төлөлт, ногдол ашиг гэх мэт)-ын талаарх мэдээлэл;

3.“Оюу толгой” ХХК-ийн 2024-2025 онд Рио Тинто компани, түүний хамаарал бүхий этгээдүүдэд шилжүүлсэн ба шилжүүлэхээр бүртгэсэн зардал, зээлийн талаарх мэдээллүүд;

4.“Оюу толгой” ХХК-ийн 2026-2030 оны олборлолт, баяжмал үйлдвэрлэл, борлуулалт, зардал, ашиг, мөнгөн гүйлгээний төсөөлөл, хэтийн төлөвлөгөө, компанийн стратегийн зорилтууд болон гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд (KPI)-ийн талаар;

5.“Оюу толгой” ХХК-ийн 2026 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл болон 2026 онд хэлэлцэх болон танилцуулахаар төлөвлөж буй асуудлуудын талаар;

6.“Оюу толгой” ХХК, “Онтрэ” ХХК-ийн нөөцийн тайлан, техник, эдийн засгийн үндэслэлүүд, уулын ажлын төлөвлөгөө болон 2026 онд холбогдох төрийн байгууллагуудаас “Онтрэ” ХХК-ийн эзэмшилд буй тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар гаргасан шийдвэрүүд, ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, үр дүнгийн талаарх мэдээлэл.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

О.БАТНАЙРАМДАЛ

2026000080